



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/86/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор сум 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг:

tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Г.Ганчимэг

Утас: 88268424

Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	9
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	10
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	12
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.МӨНХСҮХ ТАНАА

2019.02.25 № 2/50

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2519082

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Мөнхсүх-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 19-нөөс 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Төрийн үйлчилгээ ,бодлого шийдвэрийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэж тэдний санал бодлыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх, төр иргэний харилцааг дээдэлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Төр, эдийн засаг , нийгмийн бодлогын удирдлагын үйл
- Сум, багаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 568,2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 17,0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцсон.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БАЙХГҮЙ

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 332,3 сая төгрөгийн төсөв, нэмэлт санхүүжилтээр 11,0 сая төгрөг туслах үйл ажиллагааны орлогоос 0,6 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 340,5 сая төгрөг буюу 98% хувьтай зарцуулж 6,9 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс, хугацаа хоцорч мэдээлсэн 3, огт мэдээлээгүй 2 мэдээлэл байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Засаг даргын Тамгын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг явуулах зөвлөмжийн дагуу Тамгын газрын даргын 2018 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн БНА-2019/86/СТА-ТШЗ

12 тоот тушаалаар тооллогын комисс байгуулж тооллогын ажлыг зохион байгуулж дүнг 2018 оны 09 дүгээр сарын 06 ний өдрийн 77 тоот албан бичгээр ирүүлж зөвлөмжийн биелэлтийг ханган ажилласан байна.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>65,545,207.13</u>	<u>67,439,727.73</u>
33	АВЛАГА	7,569,595.00	8,076,595.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	276,595.00	276,595.00
335	Бусад авлага	7,293,000.00	7,800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,293,000.00	7,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,975,612.13	59,363,132.73
351	Түүхий эд материал	1,226,000.00	1,374,390.00
35110	Тусгай зориулалттай материал	1,226,000.00	1,374,390.00
354	Хангамжийн материал	46,219,612.13	47,047,542.73
35410	Бичиг хэргийн материал	1,944,744.00	2,248,174.00
35420	Аж ахуйн материал	28,982,462.00	29,492,462.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	00.60
35470	Бусад хангамжийн материал	15,292,406.13	15,306,906.13
35600	Мал амьтад	10,530,000.00	10,941,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,842,446,464.88</u>	<u>3,563,440,466.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,842,446,464.88	3,563,440,466.68

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

392	Биет хөрөнгө	3,842,450,631.55	3,489,523,433.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,189,969,753.50	3,878,520,980.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-679,690,055.84	-756,856,049.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,827,460.00	202,623,260.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-115,699,959.19	-115,626,899.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	134,509,748.40	150,801,748.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-84,488,724.90	-98,146,360.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,753,050.96	110,673,050.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,540,550.33	-50,233,259.05
39209	Зам, гүүрийн байгууламж	7,193,000.00	7,193,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,678,366.48	-1,858,191.46
39214	Бусад үндсэн хөрөнгө	175,094,676.00	197,494,676.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-22,799,400.57	-35,062,522.65
393	Биет бус хөрөнгө	-4,166.67	73,917,033.33
39301	Програм хангамж	1,004,060.00	1,754,060.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,008,226.67	-1,008,226.67
39303	Бусад биет бус хөрөнгө	700,000.00	73,871,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-700,000.00	-700,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,907,991,672.01</u>	<u>3,630,880,194.41</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,907,991,672.01</u>	<u>3,630,880,194.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,907,991,672.01	3,630,880,194.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	432,215,811.50	505,387,011.50
51101	Өмч: - төрийн	432,215,811.50	505,387,011.50
512	Хуримтлагдсан үр дүн	3,468,921,035.28	3,039,569,807.81
51210	Өмнөх үеийн үр дүн	3,468,921,035.28	3,468,921,035.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-429,351,227.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,854,825.23	85,923,375.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,907,991,672.01</u>	<u>3,630,880,194.41</u>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	162,389,198.00	423,021,426.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,250,000.00	62,951,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,250,000.00	62,951,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,250,000.00	62,951,850.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,250,000.00	607,860.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	62,343,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,139,198.00	360,069,576.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	13,500,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	00.00	13,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,660,240.00	11,050,000.00

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,660,240.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	11,050,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154,447,583.00	332,301,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154,447,583.00	332,301,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,031,375.00	3,217,976.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,031,375.00	3,217,976.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	245,185,197.82	568,247,761.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,185,197.82	568,247,761.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,097,839.82	523,438,748.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,942,354.00	167,945,283.00
210101	Үндсэн цалин	77,942,354.00	167,945,283.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,173,915.00	21,199,889.00
210201	Тэтгэврийн даатгал	8,173,915.00	14,470,742.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,682,286.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,345,829.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	336,458.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,364,574.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,624,800.00	20,900,651.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,715,451.00
210302	Түлш, халаалт	10,624,800.00	18,045,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	140,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,673,970.00	39,435,869.40
210401	Бичиг хэрэг	2,063,750.00	3,712,850.00
210402	Тээвэр, шатахуун	5,475,580.00	27,946,599.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	4,150,520.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	134,640.00	77,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	3,548,800.00
2105	Нормативт зардал	420,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	420,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	283,500.00	3,144,400.00
210604	Урсгал засвар	283,500.00	3,144,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	8,050,800.00
210702	Дотоод албан томилолт	00.00	8,050,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,303,500.00	3,780,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,303,500.00	3,780,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,675,300.82	258,981,255.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,615,400.00	6,402,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,059,900.82	252,578,655.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,087,358.00	44,809,013.00

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	34,450,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	34,450,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,087,358.00	3,417,976.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,031,375.00	3,217,976.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,055,983.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	321,037.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	321,037.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,620,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,620,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-82,795,999.82	-145,226,335.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	284,124,892.36
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	284,124,892.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-284,124,892.36
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-82,795,999.82	-429,351,227.47

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	335,996,023.00	347,177,436.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,400,000.00	607,860.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,400,000.00	607,860.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,400,000.00	607,860.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,400,000.00	607,860.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,596,023.00	346,569,576.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,138,715.00	11,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,138,715.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	11,050,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	320,255,183.00	332,301,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,255,183.00	332,301,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,202,125.00	3,217,976.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,202,125.00	3,217,976.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	335,996,023.00	318,510,236.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	335,996,023.00	318,510,236.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,408,167.00	267,591,223.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,535,512.00	168,388,113.00

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	161,535,512.00	168,388,113.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,076,564.00	20,757,059.00
210201	Тэтгэврийн даатгал	18,076,564.00	20,757,059.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,132,130.00	22,131,251.00
210301	Гэрэл, цахилгаан	2,011,930.00	2,796,051.00
210302	Түлш, халаалт	22,120,200.00	19,095,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,458,830.00	33,476,000.00
210401	Бичиг хэрэг	3,399,910.00	3,390,880.00
210402	Тээвэр, шатахуун	19,746,580.00	25,835,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,775,700.00	4,150,520.00
210404	Ном, хэвлэл	305,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	231,640.00	99,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,188,800.00	3,157,000.00
210604	Урсгал засвар	10,188,800.00	3,157,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,953,000.00	8,050,800.00
210702	Дотоод албан томилолт	8,953,000.00	8,050,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,181,701.00	5,692,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,181,701.00	5,692,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,881,630.00	5,938,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,881,630.00	5,938,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,587,856.00	50,919,013.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	40,460,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	40,460,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,695,508.00	3,517,976.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,202,125.00	3,217,976.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,537,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,955,983.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		321,037.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	321,037.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,892,348.00	6,620,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,892,348.00	6,620,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	28,667,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	28,667,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	28,667,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	28,667,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	28,667,200.00

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-28,667,200.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

1.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,215,811.50	6,854,825.23	3,468,921,035.28	00.00	3,907,991,672.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,215,811.50	6,854,825.23	3,468,921,035.28	00.00	3,907,991,672.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	79,068,549.87	00.00	00.00	79,068,549.87
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	73,171,200.00	00.00	-429,351,227.47	00.00	-356,180,027.47
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,923,375.10	3,039,569,807.81	00.00	3,630,880,194.41

1.18.Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,655,202.00	320,762,835.00	332,901,600.00	332,580,563.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,655,202.00	320,762,835.00	332,901,600.00	332,580,563.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286,161,821.00	282,269,452.00	263,184,400.00	263,153,363.00

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,751,100.00	161,535,512.00	168,395,100.00	168,388,113.00
210101	Үндсэн цалин	162,751,100.00	161,535,512.00	168,395,100.00	168,388,113.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,269,600.00	18,076,564.00	20,761,700.00	20,757,059.00
210201	Тэтгэврийн даатгал	18,269,600.00	18,076,564.00	14,010,100.00	20,757,059.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,687,900.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,350,300.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	337,600.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	3,375,800.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,931,231.00	24,132,130.00	22,140,300.00	22,131,251.00
210301	Гэрэл, цахилгаан	3,100,000.00	2,011,930.00	2,180,600.00	2,796,051.00
210302	Түлш, халаалт	21,831,231.00	22,120,200.00	19,369,700.00	19,095,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00	590,000.00	240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,563,490.00	26,458,830.00	33,476,000.00	33,468,140.00
210401	Бичиг хэрэг	3,299,310.00	3,399,910.00	3,208,400.00	3,383,020.00
210402	Тээвэр, шатахуун	19,746,580.00	19,746,580.00	25,835,600.00	25,835,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,775,700.00	2,775,700.00	4,333,000.00	4,150,520.00
210404	Ном, хэвлэл	291,400.00	305,000.00	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,500.00	231,640.00	99,000.00	99,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,239,400.00	10,188,800.00	3,157,500.00	3,157,000.00
210604	Урсгал засвар	10,239,400.00	10,188,800.00	3,157,500.00	3,157,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,962,000.00	8,953,000.00	8,050,800.00	8,050,800.00
210702	Дотоод албан томилолт	8,962,000.00	8,953,000.00	8,050,800.00	8,050,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,165,900.00	13,181,701.00	1,262,600.00	1,262,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,165,900.00	13,181,701.00	1,262,600.00	1,262,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,279,100.00	28,341,630.00	5,940,400.00	5,938,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,279,100.00	28,881,630.00	5,940,400.00	5,938,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,493,381.00	38,493,383.00	6,971,720.00	6,942,720.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	69,417,200.00	69,127,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	69,417,200.00	69,127,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,493,381.00	38,493,383.00	300,000.00	300,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,537,398.00	22,537,400.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,955,983.00	15,955,983.00	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	320,255,202.00	316,362,835.00	332,901,600.00	332,580,563.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	316,362,835.00	316,362,835.00	332,301,600.00	331,980,563.00

Баянлиг сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	320,255,202.00	316,362,835.00	332,301,600.00	331,980,563.00
120004	ӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,400,000.00	4,400,000.00	600,000.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,400,000.00	4,400,000.00	600,000.00	600,000.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	21.00	21.00	21.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	03.00	03.00	03.00	03.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	13.00	13.00	13.00	13.00
650009	Ажлын албаны албан хаагч (ТҮ)	05.00	05.00	05.00	05.00